

# ХАМТЫН ХҮЧИН ЧАРМАЙЛТЫН НЭГДСЭН ДҮРЭМ



Олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн хөдөлгөөнүүдийн манлайлагчид 18 сарын туршид тулгарч буй нийтлэг асуудлуудаа дүгнэн хэлэлцсэний дүнд тодорхой арга хэмжээнүүдийг хамтран хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн юм. Ингэснээр Олон улсын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн сүлжээ (ESCR-Net)-ний нийт гишүүд хамтран Хамтын хүчин чармайлын Нэгдсэн Дүрмийг боловсруулж, нийгэмд бодит өөрчлөлт бий болгох арга хэмжээ зохион байгуулах эхлэл тавигдсан юм.

Нийгмийн хөдөлгөөний нэгээхэн хэсэг болох нийгмийн анхан шатны бүлэг болон төрийн бус байгууллагууд (ТББ-ууд) бид өөр өөр хэлээр ярьдаг, өөрсдийн бие даасан түүхтэй билээ. Гэхдээ бидний үйл ажиллагааг боомилох аливаа оролдлогыг эсэргүүцэн тэмцэж байгаагаараа бид ижил юм.

## ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ БА НИЙТЛЭГ СОРИЛТУУД

**Бүгдэд хүрэлцэхүйц баялагтай дэлхийд биднийг ядуу байлгаж байна.**

Бүх хүнд хүрэлцэхүйц баялагтай дэлхийд амьдарч байгаа хэдий ч ашиг хонжоо хөөцөлдсөн харгис хэрцгий үйлдлээс болж байгаль дэлхий, түүний баялаг арилжааны бараа бүтээгдэхүүн болон хувирч, газар нутгийг ашгийн зориулалтаар булаан авч хөдөлмөрчин иргэдийн баталгаа, хамгаалалтыг үгүй хийж байна.

“Бид ядуу биш харин биднийг ядуу байлгаж байна. Бид ядууралтай тэмцэж чадахгүй ч биднийг ядууруулж буйтай тэмцэж чадна.” -Мкхалисени Ндабох Мзимела, Абахлани Басемжондоло, Өмнөд Африк

“Дэлхий даяар бүгдэд нь хүрэлцэхүйц хоол хүнс үйлдвэрлэж 815 сая хүн өлсгөлөнд нэрвэгдсэн хэвээр байна.”  
-Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн тайлан, 2017 он

**Хүчирхэг корпорациуд бидний хүч хөдөлмөрөөрөө бүтээсэн ардчиллын институцийг хянаж байна.**

Дэлхийн нийт баялаг цөөнхийн эрх мэдэлд шилжиж, ард иргэд, хүний эрх, байгаль орчны эрх ашгийг хөсөрдүүлсэн сонгууль, хууль эрх зүй, эдийн засгийн бодлогыг тодорхойлж, төрийн байгууллагуудыг эрхшээлдээ байлгаж байна.

**Тэгш бус байдал тэлэхийн хэрээр бидний эрхэм чанар, сайн сайхан байдлыг үгүй хийж байна.**

Үндсэрхэг, эмзэг бүлгийг гадуурхах үзэл нь тэгш бус байдлыг гааруулж, эсэргүүцлийг өдөөдөг гэдгийг түүх бидэнд харуулсан. Хэдийгээр эмэгтэйчүүд, цагаачид болон нийгмийн бусад эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлт нийгмийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулдаг учраас эрэлттэй байдаг хэдий ч хөдөлмөрийн хөлсийг үнэлэхгүй, төлөхгүй байх тохиолдол тогтмол гарч байна. Бидний өнөөгийн эдийн засгийн тогтолцоо цөөн хэдэн элит бүлгийн эрх мэдэлд хөрөнгийг хуваарилж байгаа бол нөгөө хэсэг болох хүн төрөлхтний дийлэнх хэсэг нь зохистой түвшинд амьдралаа залгуулахад хүндрэлтэй тулгарч байна.

Хөрөнгө, бараа бүтээгдэхүүнийг хил дамнуулах хялбар болсон ч дийлэнх цагаач ажилчид “хууль бус” гэж цоллогдон, хамгаалалтгүй хэвээр үлдсээр байна.


**Байгаль орчин эргэж сэргэшгүйгээр доройтож байна.**

Хэсэг бүлэг хүмүүсийн ашгийн төлөө байгалийн баялгийг хайр гамгүй олборлон, шатамхай хийг ашигласнаар байгаль цаг уурын өөрчлөлтөд орж, энэ дэлхийд амьдарч буй бүх хүний амьдрал, амь нас, эрүүл мэнд доройтож байна. Нийгмийн эмзэг бүлгийнхэн эрсдэлд илүү өртөж байна.

**Биднийг эрхээ шаардсаны төлөө шахан хавчиж байна.**

Биднийг хүний эрхийн төлөө тэмцэж, хамгаалсаны төлөө төр засаг, цэрэг цагдаа, компаниуд, бусад хувийн хэвшлийнхэн мөрдөн мөшгиж, гутаан доромжилж, бидний эсрэг хүчирхийллийг сонгон, сүрдүүлэг, заналхийллийг санхүүжүүлж байна.

Дээрх нийтлэг нөхцөл байдал, сорилтуудыг шийдвэрлэхдээ бид зөвхөн аливаа асуудал тэрсн дараа хариу үйлдэл үзүүлдэг бус харин асуудал гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллаж, тулгарч буй нийтлэг асуудлуудын суурь шалтгаантай дараах чиглэлээр тэмцэх юм.



# БИДНИЙ НЭГДЭХ ГОЛ ШАЛТГААН

“Таны асуудал бол миний асуудал,  
таны тэмцэл бол миний тэмцэл.”  
-Херман Кумара, Үндэсний загасчдын  
эв санааны байгууллага, Шри Ланка

## ХҮНИЙ ЭРХИЙГ СЭРГЭЭХ

Хүний эрх бол биднийг төрөхөд хамт бий болсон салшгүй эрх бөгөөд хүний эрх, тэгш байдал, сайн сайхны төлөө хийсэн уйгагүй тэмцлийн үр дүнд дэлхий нийтийн стандарт, хэм хэмжээ болон тогтсон юм. Бид хүний эрхийг сэргээхийг шаардаж, шударга ёсны төлөөх шаардлагаа нэхэмжилдэг.

## ТЭМЦЛЭЭ НЭГТГЭХ

Бид баян эсхүл ядуу орон, хот эсхүл хөдөөд амьдардагаас үл хамааран тэмцэл, хүчин чармайлтаа хэрхэн нэгдэж чадахаас бидний амжилт шалтгаална. Тогтолцооны хямралыг арилгахын тулд бид хамтран:

- Төрийн байгууллага, түүний шийдвэр, үйл ажиллагааг хянаж буй корпорациудтай тэмцэж
- Эрх тэгш амьдрал, амьд явах, аж төрөх түгээмэл, үл маргах эрхүүдийг ханган, хамгаалах , төрийн үүрэг хариуцлагыг баталгаажуулах
- “Хөгжлийн үнэ цэнэ” гэдэг нэрийн дор явагдаж буй ашгийн төлөөх ёс зүйгүй үйлдлийг бид хөндөж гаргана.

“Бид ашиг гэдэг зүйлийг муу үг болгон хэвшүүлэх хэрэгтэй”  
-Легборзи Саро Пуагбара, Огонигийн иргэдийн амьд гарах хөдөлгөөн, Нигер

“Хэрэгцээнд хязгаар бий, шуналд хязгаар үгүй”-Прафулла Самангара, Лок Абхай Шакти, БНЭУ

## ОРХИГДСОН БҮЛГҮҮДИЙН МАНЛАЙЛАГЧДЫГ НЭГТГЭХ

Бидний эргэн тойрны өнөөгийн нөхцөл байдал нь тэмцэгч бүлгүүд төрөн гарч, тодорхой ажлууд хийхэд хүргэж байна. Бид өөрсдийн бодит туршлагадаа тулгуурлан ядуу эмзэг бүлэг, эмэгтэйчүүд, залуучуудын манлайллыг хөхиүлэн дэмжиж, өөрсдийн нийтлэг асуудалд дүн шинжилгээ хийж, үйл ажиллагаагаа зохион байгуулалттайгаар эрчимжүүлнэ.

Олон улсын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн сүлжээний хөдөлгөөнүүд нэгэн ижил зүйлийг шаардаж байгаа бөгөөд энэ нь нийгмийн эмзэг бүлэг болон хүний эрхийн төлөө тэмцэгчдийн эсрэг үйлдэгдэх ядуурал, хүчирхийллийг таслан зогсоох явдал юм. –Айда ЛеБланк, Үндэсний ажилчдын холбоо, Тринидад Тобаго

## ОЛОН ХУВИЛБАРТ ЗАГВАР БОЛОВСРУУЛАХ

Бид хамтдаа энэ дэлхийд:

- Хүний мөн чанарыг хадгалан, бие биетэйгээ хоршин амьдрах, ирээдүй хойч үедээ үлдээх ухамсарт ёс зүйг төлөвшүүлэн,
- Хөгжил дэвшлийн гол тулгуур болсон жендэрийн тэгш байдлыг бодитоор ханган,
- Тэмцлийг өрнүүлэх, “эрхээ шаардах эрх”-ийг хангах орон зайг бий болгон баталгаажуулж,
- Оролцоог хангасан ирээдүйг бий болгож, аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид, бүрэн оролцоотой, сайн сайхан аж төрөх ирээдүйг цогцлоохыг хүсэж байна.

**ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХӨДӨЛГӨӨН БОЛОН БАЙГУУЛЛАГА ДОТРОО ЯРИЛЦАНА УУ ДАРААХ ЧИГЛЭЛЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНҮҮЛНЭ ҮҮ**

Дээрх нийтлэг сорилт, асуудлууд нь Та бүхний ажилтай хэрхэн уялдаж байна вэ?

Бидний тэмцэл нийтлэг зорилготой гэдгийг ойлгож мэдсэнээрээ

Цаашид урагш алхах ямар арга зам байна вэ?

Та өөрийн санаа бодлоо бидэнтэй дараах хаягаар хуваалцана уу: [cc@escr-net.org](mailto:cc@escr-net.org)

الشبكة العالمية  
للحقوق الاقتصادية  
والاجتماعية والثقافية



ESCR-Net  
Red-DESC  
Réseau-DESC

ESCR-Net буюу Олон улсын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн сүлжээ нь дэлхийн 75 орны эдийн засаг, нийгмийн шударга ёс, хүний эрхийг хамгаалах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг 280 гаруй иргэний хөдөлгөөн, төрийн бус байгууллагуудыг эгнээндээ багтаасан байгууллага юм. Нэгдсэн арга хэмжээг хамтран хэрэгжүүлснээр бүс нутгийн харилцаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлж, сүлжээгээрээ дамжуулан хүний эрх, нийгмийн шударга ёсыг бодитоор хангах дэлхийн хөдөлгөөнийг бий болгох зорилготой. EN-03-00